

Манмин Мэдээ

№ 73 2019 оны 6 сарын 23

“Бурхан хамт байдаг Манмины үйлчлэл гайхамшигтай”

Индонезийн 120гаруй номлогчид манай сүмд зочлов



5-р сарын 4-5нд Индонезийн 120гаруй номлогчид манай сүмд зочлон ирж, Манмины үйлчлэлтэй танилцаж, амьд орших Бурхандаа талархал ба алдрыг өргөлөө.

Эхний үйл ажиллагаа 5-р сарын 4ны орой 9цаг 20минут, 3-р их танхимд нээгдсэн номлогчдын семинарт төв сүмийн урлагын багт хамаарах Кристалл, Есүл баг, Power worship, Солонгос бүжиг зэргээр оролцогчдод ивээл болон асар их сэтгэгдэл хөдлөл ба ивээлээр бялхсан цаг байлаа (Зураг 2, 6). Үргэлжлүүлэн И Жей руг тэргүүн пастораар дамжуулан гарах эрх мэдэлт хүчит үйлчлэл, Христчин телевиз, хэвлэл мэдээлэлээр авралын зар тараах тухай видео танилцуулга үзэгдэсэн юм.

Үүний дараа уг семинарын номлогч И Сү жин пастор

“Манай сүмийн сэргэлтийн нууц бол эрх мэдэлт хүчний үйлчлэл, гал мэт халуун залбирал, амийн үг сургаал юм” гэж айлдсаны дараа авралын зарын гол цөм болох “Есүс яагаад бидний аврагч Эзэн болсоны учир” талаар маш нарийн тодорхой тайлбарлаж өгсөн юм (Зураг 1). Семинарын И Жей руг пасторын залбирал хийж өгсөн гар алчуур (Үйлс 19:11-12) аар залбирал авсан Марта Дендэн пастор (Чирүнси чуулган) өвдөгний үе мөчний үрэвсэлийн улмаас алхаж чадахгүй байсан бол залбирал авсаны дараа зовиургүй болж сайн алхдаг болсон юм (Зураг 3, 4).

5-р сарын Бөдөр Эзэний өдрийн их мөргөл ба Үдээс хойш мөргөлд оролцож (Зураг 5) ялангуяа 30гаруй номлогч нар Индонези үндэсний хувцас батик өмсөн онцгой дуу дуулж итгэгч нарт баяр хөөр ивээлийг өгсөн

цаг байв (Зураг 9). Адриан Саройнсонг пастор (Бэтлэхэм чуулганы хариуцагч)-н мэндчилгээгээр дамжуулан “Яг л тэнгэрийн оронд очсон мэт байлаа. Ариун хоор дуу, Нисси оркестр, магтаал ба вошип бүжгээр дамжуулан Ариун Сүнсний бялхалыг мэдэрч, үнэхээр сайхан цуглаантай хамт байгаадаа үнэхээр талархалтай байна” гэсэн юм (Зураг 7).

Үргэлжлүүлэн Индонези номлогчдын бүрэлдэхүүнийг ахлаж буй Катуж Караван (эм) пастор (Бэтлэхэм чуулган) И Жей руг тэргүүн пасторт өргөх талархалын зүйлсийг ерөнхий удирдагч И Сү жин пасторт гардуулан өглөө (Зураг 8).

Үүнээс гадна Мүан амтат усны хүрээлэнд очиж сонирхож, GCN телевизд зочлон, оройн Даниел залбиралд оролцох зэрэг хөтөлбөртэй байлаа (Зураг 10).

“Зөвхөн Есүс Христ төвтэй чуулган байлаа!”

Полке Дени Коюнжа пастор (Христ төвт чуулган АНУ)



Энэ удаагын айлчлалаар дамжуулан Манмин Төв чуулган нь библи дээр бичигдсэн эрх мэдэлт хүч нөлөө гардаг чуулган болохыг мэдэрсэн юм. Сүм чуулганд ийм эрх мэдэлт хүч нөлөө тэмдэг гайхамшиг гарна гэдэг

их ерөөл юм.

Бурхан Манмин Төв чуулганаар дамжуулан тэмдэг гайхамшигийг үзүүлж, бид бүхэн энэ бүгдийг харж чадах боломж өгсөнд талархаж, маш баяр хөөртэй байна.

Би энэ газар ирэхийн өмнө, найзууд болон хүмүүс Манмин Төв чуулганы тухай төдийлөн сайн ярихгүй байсан ба Индонези чуулганууд Манмин

Төв чуулган бол хүнийг дөвийлгөн шүтдэг, гэсэн яриа ч сонсож байлаа. Гэтэл энэ газар бол эрх мэдэлт хүч гардаг чуулган, бүх хүмүүст Есүс Христийн тухай дамжуулдаг И Жей руг тэргүүн пастор зөвхөн итгэлээр амьдардаг бөгөөд тэрээр зөвхөн залбирал ба мацаг барилтаар амьдардаг болохыг мэдсэн юм. Мөн үргэлж Бурхан болон Эзэндээ алдрыг өргөж байлаа.

Би эндээс мэдэрсэн гэрчлэлүүдээ итгэгч нартаа дамжуулан тэд нарт ч гэсэн итгэл болоосой гэж хүсэж байна. Мөн олон хүмүүс Манмин Төв чуулган д зочлон ирж, Ариун Сүнсний хүч нөлөө хэрхэн нөлөөлж байгааг мөн тэр сэтгэл хөдлөлийг мэдрээсэй гэж хүсэж байна. Энд ирээд үзвэл ерөөгдөх боломжтой юм. Биднийг найрсагаар угтаж, үйлчилж өгсөн Манмин Төв чуулганд чин сэтгэлээсээ талархаж байна.

2019 Хүүхдийн өдрийн Эзэний өдрийн мөргөл

5-р сарын 5ны өдөр үдээс хойш 1цаг 30минут, GCN телевиз болон интернэтээр дамжуулан дэлхий даяар шууд дамжуулж 2-р их танхимд Хүүхдийн цуглааны Хүүхдийн өдрийн мөргөлийг өргөлөө. Номлогч И Ми ёон пастор (3-р Их бүлгийн хариуцагч) “Манмины бахархал” (1 Коринт 11:1) гэсэн сэдвээр “Бурханыг хайрлаж итгэмжтэйгээр итгэлээр амьдарч Тэнгэрийн хүслээр дүүрэн урагш давшихыг” захиж хэлсэн юм.



Хайр бол энэрэнгүй дөлгөөн юм

“Хайр бол тэвчээртэй, энэрэнгүй юм.
Хайр атаархдаггүй, бардам зан гаргадаггүй, ихэрхдэггүй.”
1 Коринт 13:4

Манмин Төв сүмийн тэргүүн пастор И Жей руг пастор

Грекийн алдартай Есүгийн ёгт үлгэрт нар ба салхины үлгэр гардаг. Нэгэн өдөр нар ба салхи замаар явж буй хүний гадуур хувцасыг хэн нь түрүүлж тайлуулах вэ гэж мөрийцсөн байна. Эхлээд салхи өөртөө маш итгэлтэйгээр ургаа мод ч үндсээрээ сугарч болох хүчтэй үлээлээ. Өнөөх аяны хүн энэ хүчтэй салхинд гадуур хувцсаа хийсгэчих вий гэж энгэрээ илүү сайн товчлон элгээ тэврэв. Дараа нь нарын ээлж ирэхэд тэрээр маш тайвнаар инээмсэглэн дулаахан илчээр төөнөж эхлэв. Цаг агаар дулаарч, халууцсан аянчин хурдхан гадуур хувцсаа тайлав.

Энэ үлгэр нь бидэнд чухал сургамж өгч байна. Салхи өөрийн хүчээр хүний гадуур хувцсыг тайлах гэсэн боловч харин нар аянчны хувцсыг өөрөөр нь тайлуулсан юм. Үүний адил энэрэнгүй дөлгөөн сэтгэл нь хүч хэрэглэх бус, сайн болон хайраар хүний сэтгэлийг хөдөлгөж, бусдын сэтгэлд хүлээн зөвшөөрөгддөг.

1. Бүх хүмүүсийг өвөрлөж чадах дөлгөөн сэтгэл

‘Дөлгөөн зан’ гэдэг нь бүх хүмүүсийг өвөрлөж чадах сэтгэл, олон хүмүүс цуглаж амралт олж чадах сэтгэлийг хэлдэг. Толь бичигт үзвэл ‘Зөөлөн, даруу, эелдэг, зөөлөн дулаан мэдрэмж’ гэж тодорхойлсон байдаг.

Хөвөнг төсөөлж үзвэл дөлгөөн сэтгэлийг ойлгоход амархан юм. Хичнээн хатуу биетэй зүйлээр хөвөнг цохих юм уу шидэхэд хөвөн шууд бүчиж авч дуу ч гардаггүй шиг, дөлгөөн хүн бүх хүмүүсийг өвөрлөж чадах юм. Мөн олон хүмүүс сүүдэрт нь сууж амарч сэрүүцдэг том модтой адил юм. Халуу шатсан аагим халуун зуны өдөр том сүүдэртэй модны дор орж зогсоход сэрүүхэн таатай байдаг шиг дөлгөөн сэтгэлтэй хүний хажууд олон хүмүүс цугларч хамт байхыг хүсдэг.

Элбэг тохиолдох зан ааш даруухан ба хэн нэгэн юу ч гэж хэлсэн ч уурлалгүй, өөрийн гэсэн үзэл бодол сул хүмүүсийг ер нь даруу дөлгөөн хүн гэдэг. Гэтэл хичнээн цайлган цагаахан байсан ч Бурханы хүлээн зөвшөөрөх цайлган зан биш л бол жинхэнэ дөлгөөн хүн гэх боломжгүй юм.

Бурханы хүсэж буй ‘Сүнс талын дөлгөөн байдал’ нь зүрх сэтгэлдээ хорон муугүй, мэргэн ухаантай, сүнслэг хайраар дүүрэн ямар ч атга

хүнтэй тэрсэлддэггүй өвөрлөдөг сэтгэл юм. Мэдээж даруу дөлгөөн гээд шууд л ойлгож өгөөд уучлах бус, заримдаа хүний зөв чиглүүлж, удирдах хэмжээний сүр хүч бас байх ёстой юм. Тийм учраас жинхэнэ дөлгөөхөн хүн сайн цайлган байх төдийгүй үйлдэл төгс болон ухаалаг байх ёстой юм.

‘Сүнс талын дөлгөөн байдал’-г илүү нарийн тайлбарлавал дотроо даруу дөлгөөн мөртлөө гаднаа шударга, ачлалт байдлыг хамтатгасан байх ёстой гэдэг. Хорон муу байхгүй сайн цайлган сэтгэлтэй байлаа ч тэр нь дотроо байх тул бусдыг чиглүүлж удирдахад тэр байдал нь хүрч чаддаггүй. Дотоод дөлгөөн сэтгэлийн хамт гаднаа шударга бөгөөд ачлалт сэтгэлтэй нэгдсэнээр төгс болж илүү хүчтэй нөлөөлөх боломжтой юм. Ийм дөлгөөн сэтгэл ба шударга, ачлалт байдлыг бий болгосон хүн олон хүнийг сэтгэлийг хөдөлгөснөөр том ажил хийж чадах юм.

Энгийнээр бодоход хүмүүс хайр гэж зөвхөн уучилж, ойлгож өгдөг, алдааг нь далдалж өгдөг, дулаан зөөлөн зүйл гэж боддог. Гэтэл жинхэнэ хайр бол ёс бус байдлыг уучилдаггүй бөгөөд хайрын уг үндэс болох Бурхан хязгааргүй энэрэл нигүүлслээр ханддаг ч заримдаа хорон муу үйлдэлийг маш хатуу шүүдэг юм (Тооллого 14:18). Бурхан шударга байдал дотор зэмлэж, шийтгэдэг нь хайрт хүүхдүүдээ мөнх амь руу хөтлөхийн төлөө хайрын үйлдэл юм.

Хайр ба шударга байдал нь харилцан бие биенээ нөхдөг шиг дөлгөөн байдал ба ачит сэтгэл ч мөн тийм юм. Сэтгэл нь сайн ба дөлгөөхөн, хайр ба энэрэнгүй их байх төдийгүй хүмүүсийг зөв замаар чиглүүлж чадах шударга сэтгэл хамтдаа байж жинхэнэ сүнслэг хайрын үйлс илрэн гардаг. Энэ мэт сүнслэг дөлгөөн байдал нь дээр дурьдсанчлан шударга ачлалт хамт байж л олон хүмүүсийг зөв замаар чиглүүлж, авралын зам руу хөтөлж өгдөг.

2. Дотоод дөлгөөн байдлыг бий болгох хэмжүүр нь ариун байдал юм

‘Дөлгөөн сэтгэл’-г бий болгохын төлөө эхлээд юуны түрүүнд зүрх сэтгэлийн хорон мууг хаяж ариун байдлыг олох хэрэгтэй. Ариун байдлыг олсон хүн хөвөн мэт тул хэн нэгэн дайралт хийж

ирлээ ч дуу шуу гарахгүй ба зөөлнөөр бүрхээд авдагтай адил юм. Сэтгэлд хорон муу байхгүй тул хэн нэгэнтэй бүдрэх тулах явдал байдаггүй. Гэхдээ үзэн ядалт, атаархал зэрэг өчүүхэн сэтгэл юм уу өөрийн үзэл бодол чулуу шиг хатуу бол бусдыг өвөрлөж чадахгүй юм.

Хатуу чулуу, төмөр зэрэг нь доош унахдаа чанга дуугарч, үсэрч, ойдог шиг би гэх сэтгэл байгаа бусад хүн жоохон тавгүйтүүлвэл дургүй сэтгэл нь ил гардаг. Алдаа дутагдал, өө сэв нь харагддаг хүнийг хараад ойлгож өгч, алдааг хучиж өгөхийн оронд дүгнэж шүүн, хов жив ярьдаг. Ийм хүн сэтгэл нь юу ч хийе гэсэн хэдийн бялхаж цалгиж асгадаг, жижигхэн сав мэт юм. Эсвэл тэр саван дотор элдэв хэрэггүй жижиг сажиг бохир зүйлүүд дүүрэн байх тул илүү ихийг багтааж чадахгүй жижиг сэтгэл юм.

Жишээ нь хэн нэгэнээр зэмлүүлэх үедээ эсвэл шүүмжлүүлэх үед нүүр нь улайж, сэтгэл нь шархлах, бусад хүн аяархан юм ярьж байгааг хараад “Миний талаар ярьж байгаа юм болов уу?” гэж шохоорхож “Зэрвэсхэн харахад тэд миний талаар ярьж байна” гэж дүгнэн боддог.

Тиймээс сэтгэлдээ хорон муу байхгүй байх нь дөлгөөн байдлын суурь нөхцөл юм. Бусдыг сайн ба хайраар хардаг учраас дөлгөөхөн хүн цаг үргэлж энэрэнгүй зөөлнөөр харж хүлээж авдаг болохоор юм. Дүгнэх шүүх сэтгэл огт байхгүй учраас яадаг ч байсан сайн ба хайраар ойлгох гэж хичээх тул хорон муу хүн ч тэр дулаахан байдалд нь уярдаг.

Ялангуяа олон хүнд зааж, удирддаг хүний сэтгэл ариун байдлыг олох нь маш чухал юм. Хорон муу байгаа хэрээр махан биеийн бодолд автаж, зөв шударга ялгах явдал байхгүй тул олон хүмүүсийн ногоон бэлчээр ба дөлгөөн ус руу удирдах боломжгүй юм.

Төгс ариун байдлыг олж байж л Ариун Сүнсний удирдамжыг маш тодорхой авч, итгэгч нарынхаа нөхцөл байдлыг 100% тодорхойлж хамгийн замаар удирдах боломжтой юм. Тэгэх үед Бурхан ‘Үнэхээр дөлгөөн байна’ гэж хүлээн зөвшөөрдөг юм.

3. Сүнс талын дөлгөөн байдлыг төгс болгодог ачлалт сэтгэл

Сүнс талын дөлгөөн байдлыг бий болгохын


Монгол Манмин Сүм

Мөргөлийн цаг

| Мөргөл | Цаг |
|-------------------------------|--------------------|
| Их мөргөл | Ням гариг 10:30 |
| Үдээс хойш мөргөл | Ням гариг 13:30 |
| Хүүхдийн цуглаан | Ням гариг 10:00 |
| 3 дахь өдрийн мөргөл | Лхагва гариг 18:00 |
| 5 дахь өдрийн мөргөл | Баасан гариг 22:00 |
| Эмэгтэйчүүдийн багийн цуглаан | Лхагва гариг 16:00 |
| Шинэ итгэгч нарын сургалт | Бямба гариг 14:00 |

Залбирлын цаг Цаг

| Ангилал | Цаг |
|------------------------|-------------------------|
| Даниел үүрийн залбирал | Даваа-баасан 5:00-6:00 |
| Даниел өдрийн залбирал | Даваа-баасан 9:00-10:00 |
| Даниел оройн залбирал | Өдөр бүр 18:30-20:00 |



Хаяг: Баянгол дүүрэг 16-р хороо Орхоны 1-33А Чуулганы ахлагч П.Батзориг
Утас: 88107327, 91170773, 89737773

www.manmin.org
www.gcntv.org

тулд ариун байх төдийгүй ачлалт сэтгэлтэй байх хэрэгтэй юм. Энгийн байдлаар үүнийг тайлбарлавал "Тэгш шударгаар бусдыг ойлгож хүлээж авах сэтгэл, ёс суртахууны үйлдэл" гэж тодорхойлж болох юм. Сүнс талын утга ч мөн адил юм. Ийм сэтгэлтэй хүн нь зүрх сэтгэл нь зөв зохистой, эрх тэгш, ёс зүйд нийцэх үйлс хийдэг. Хүч хэрэглэх бус зөв цэгцтэй үг ба үйлдлээр бусдын дутагдлыг ойлгож өвөрлөнгөө бусад сэтгэлийг олж авдаг. Ийм хүн нь өөр хүмүүст найдвар төрүүлж хайр хүндэтгэл авдаг.

Хичнээн агуу чадварлаг хүн байлаа ч чармай нүцгэн байвал гутамшигтай байдаг шиг дөлгөөн байдалд ачлалт сэтгэл жинхэнэ үнэ цэнэгүй болох юм. Хэдий зүрх сэтгэл нь дөлгөөхөн ч юм ярихдаа хэрэггүй нуршуу яриатай хүн байдаг. Ийм хүнд ямар нэг хорон муу байхгүй ч хүмүүжил төлөвшил байхгүй тул бусдад найдвар төрүүлж чаддаггүй. Мөн зүрх сэтгэл нь даруу дөлгөөн болохоор муу сэтгэл өвөрлөх юм уу бусдад хохирол учруулах зүйл байхгүй ч бусад хүмүүсийн ажилд идэвхийлэн туслах юм уу анхаарал халамжаар дутвал мөн л бусдын сэтгэлийг олоход хэцүү юм.

Тухайлбал маш гоёмсог өнгө, анхилуун үнэргүй цэцэг хичнээн бал ихтэй байсан ч зөгий болон эрвээхийг дуудан цуглуулахад хэцүү юм. Үүний нэгэн адилаар сэтгэл нь даруу дөлгөөн ч баруун хацрыг нь алгавал зүүн хацраа тавьж өгч чадах хүн ч үг ба үйлсэд нь ачлалт сэтгэл байхгүй бол дөлгөөн байдал жинхэнэ утгаараа мэдрэгдэх боломжгүй юм. Дотоод дөлгөөн шинж чанар гадна ачлалт сэтгэлтэй хамтдаа байж жинхэнэ дөлгөөн сэтгэл гарах бөгөөд түүний анхилуун үнэр гарах юм.

Иосеф нь эх өөр ах нарынхаа үзэн ядалтаар балчир насандаа Египет рүү худалдагдсан ч Бурханы тусламжтайгаар 30 настайдаа ерөнхий сайдыг байр сууринд хүрсэн юм. Хэрэв түүнд өчүүхэн төдий дутагдал байсан бол энэ байраа хадгалахад маш хэцүү байлаа. Гэхдээ Иосеф маань даруу дөлгөөхөн төдийгүй үг ба үйлдэлдээ ямар ч өө сэвгүй ба удирдагч хүнийхээ хувьд мэргэн ухаан ба сүр хүчтэй байсан юм.

Хааны дараагийн байр сууринд байсан ч эрх барих юм уу өргөмжлөх гээгүй юм. Өөртөө хатуу шаардлага тавьдаг ч бусдад өргөн уужим зөөлөн байлаа. Тийм ч учраас хаан болон бусад түшмэдүүд Иосефт хатуурхах, эсвэл атаархаж өрсөлдөх бус харин эсрэгээрээ бүх сэтгэлээрээ итгэж найддаг байсан юм. Хожим Египет хүмүүс өлсгөлөн болж буй Канаан газраас дайжин ирж буй Иосефийн хамаатнуудыг хичнээн таатай утгаж байгааг үүгээр мэдэх боломжтой юм.

Ийм ачлалт сэтгэл нь цэгцтэй үг ба үйлдэлтэй гээд бусдыг өөрийн хэмжүүрээр дүгнэх шүүдэггүй уудам зүрх сэтгэл юм. Иосеф өөрийг нь худалдсан ах нартаа яаж хандсаныг нь хараад л түүний ийм дүр төрхийг сайн мэдэх боломжтой юм. Ах нарыг гэмийн хариуг өгөх хангалттай эрх мэдэлтэй ч тэднийг гэмшиж, Бурхантай холбоотой гэмийн ханыг нураах боломжыг өгсөн юм. Шууд л шийтгэх юм уу уучилж өгөх бус ах нар өөрсдийн буруугаа хүлээж нөхцөл байдлыг бүрдүүлж эцэстээ өөрсдийн буруутай байдлаа санаж гэмшсэний дараа өөрийгөө илчилдэг.

Иосеф айн сандарч байгаа ах нараа чин сэтгэлээсээ уучилсан төдийгүй тэдний сэтгэлийг мэдэрч сэтгэл хөдлөм үгээр тэднийг тайтгаруулсан байдаг (Эхлэл 45:5). Дайсныхаа ч гэсэн сэтгэлийг хөдөлгөж чадах үйлс, өөрөөр хэлбэл гаднаа шударга, ачлалт сэтгэлтэй гэсэн үг юм. Иосефийн ачлалт сэтгэл дөлгөөн байдал нь өлсгөлөн нэрвэгдэж буй Египет ба тэр ойр орчмын үй олон хүмүүсийн аминд орох хүчтэй байсан бөгөөд Бурханы хүсэл ба зорилгыг биелүүлэх үндэс болсон юм. Энэ мэт ачлалт байдал нь зүрх сэтгэлд буй дөлгөөн байдлаар идэвхитэй үйлсээр илрэн гардаг тул олон хүмүүсийн сэтгэлийн олж, гайхамшигт хүчийг гаргадаг.

4. Ачлалт сэтгэлийг бий болгохын тулд зүрх сэтгэлийн уг үндсийг ариун болгох хэрэгтэй

Дотоод дөлгөөн сэтгэл ариун байдлаар бий

болдог шиг ачлалт байдал ч мөн хорон муу гаж, ариун байдлыг олсон үед л бий болох боломжтой. Мэдээж ариун байдлыг олж чадаагүй ч өөрийн хүмүүжил төлөвлөөр эсвэл уг зүрх сэтгэл нь уужим бол ачлалт үйлс гарах ч үе байдаг. Гэхдээ жинхэнэ ачлалт байдал нь хорон муу байхгүй сэтгэл, үнэнийг дагах сэтгэлээс л гардаг зүйл юм.

Үүнийг өөртөө төгс бий болгохын тулд хорон муугийн хэлбэрийг бүгдийг хаяад (1 Тесалоник 5:22), Тэнгэрлэг Эцэг тань төгс байдаг шиг бид ч төгс байх ёстой юм (Матай 5:48). Дотроо хорон муу байхгүй төдийгүй үг яриа, үйлдэл биеэ авч явах байдал ч өө сэвгүй байх үед л олон хүн цуглаж чадах дөлгөөн сэтгэлийг бий болгож чадах юм. Энгийн л үзэн ядалт, атаархал, бардамнал, уур уцаар зэрэг хорон муутайгаа тэмцэх бус сургаалийн дагуу гал мэт залбирлын дунд Ариун Сүнсний удирдамжыг авч, биеийн өчүүхэн үйлсийг ч үнэнээр өөрчлөх ёстой юм (Ром 8:13).

Биеийн үйлсэд хулгай, хүч хэрэглэх зэрэг илэрхий гэмт үйлдэл төдийгүй төгс бус үйлдлүүд ч хамаарах юм. Ярилцахдаа, инээхдээ зуршил ёсоор хажууд хүнээ цохих, цаг үе, орчин хамаарсан байдлаар чангаар ярьж эргэн тойронд хүндрэл учруулах зэрэг юм. Ачлалт сэтгэлтэй хүн нь Эзэнээр хүмүүжигдэх тул ийм өчүүхэн үйлс ч зөв цэгцтэй болгодог тул олон хүмүүс цуглахыг, ойр байхыг хүсдэг байна.

Мөн ийм ачлалт байдлыг бий болгохын тулд зүрх сэтгэлийн уг шинж чанарыг сууриар нь өөрчлөх хэрэгтэй юм. Энэ нь зүрх сэтгэлийн хэмжээ буюу багтаамжыг хэлж байгаа юм. Зүрх сэтгэлийн хэмжээнээс шалтгаалж зарим хүн өөрийн хийх ёстойгоос илүүг хийдэг бол, зарим нь хийх ёстойгоо дөнгөж л гүйцээх юмуу эсвэл тэгж чадахгүй тохиолдол их байдаг. Ачлалт сэтгэлтэй хүний сэтгэл том, уужим тул өөрийн хийх зүйл төдийгүй эргэн тойрныхоо хүмүүсийн ажилд ч санаа тавьдаг байна (Филиппой 2:4).

Зүрх сэтгэлийн уг шинж чанар нь өөрийгөө хэр зэрэг сэтгэлээ өргөтгөн ашиглаж байгаагаас шалтгаалан өөрчлөгдөх тул тууштай хичээл зүтгэлээр дамжуулан өөрчлөгдөх боломжтой юм. Өөрийгөө хэр зэрэг эргэн харж, өчүүхэн

жигжиг сэтгэл бол сэтгэлээ өргөтгөхийн төлөө маш нарийн тодорхой залбирч, Ариун Сүнсний тусламжыг авах ёстой юм.

Энэ мэт хорон муу байхгүй дөлгөөн сэтгэлд ачлалт байдлыг бий болгосон бол өөрийн хамаарах багт төрөл бүрийн хүмүүсийг маш амархан удирдан чиглүүлэх боломжтой юм. Өнөө үеийн лидерүүдэд зайлшгүй байх ёстой чанар юм.

5. Дөлгөөн хүний авдаг ерөөл


Матай номын 5:5д "Дөлгөөн хүмүүс ерөөлтэй ээ! Учир нь тэд дэлхийг өвлөн авах болно" гэсэн бол Дуулал 37:11д "Харин даруу хүн газар нутгыг өвлөж, Элбэг амар амгалангаар баярлана" гэсэн байдаг. Энэ хэлж буй газар нь тэнгэрийн орны байр суурийг хэлж байгаа бөгөөд, газрыг өвлөн авна гэдэг нь тэнгэрийн оронд агуу эрх мэдлийг эзэмшинэ гэсэн үг юм.

Дөлгөөн хүн нь Бурханы сэтгэлээр хүмүүст хүч өгч, ивээл өгдөг тул дөлгөөн байх тусам олон хүмүүс цуглаж, тэдний аврал руу удирдах учраас юм. Энэ мэт агуу хүн болно гэдэг нь тэр хэмжээгээр үйлчилдэг гэдгийн баталгаа юм. Тэнгэрийн орны эрх мэдэл нь үйлчилдэг хүнд өгөгддөг тул үйлчилдэг нэгэн болох тусам агуу хүн болдог. Түүнчлэн дөлгөөн хүн нь хожим тэнгэрийн оронд агуу эрх мэдлийг эдэлж, тэр хэмжээний уудам газрыг өвлөж авах юм.

Энэ газрыг эрх мэдэл нь ихэнхдээ нэр алдар унахад орхигддог бол дөлгөөн хүнд дагалдах хүч нь өөр юм. Алга болох, өөрчлөгдөх зүйл гэж байхгүй. Энэ газарт сүнс сэтгэл сайжрах тусам бүх зүйл сайжрах ерөөл авах төдийгүй, тэнгэрийн оронд ч мөнхийн мөнхөд Бурханы хайрыг аван үй олон хүмүүсийн хүндэлдэг хүн болох юм.

Хайрт итгэгч та бүхэн,

Дотоод сэтгэлдээ дөлгөөн байдалтай хамт ачит сэтгэлийг бий болгосон хүн олон сэтгэлийг олсоноороо том ажил хийх боломжтой байдаг. Ийм сүнс талын дөлгөөн байдлыг бий болгоод хожим тэнгэрийн оронд агуу эрх мэдлийг эзэмшин Бурханы сэнтийд ойрхон очих ерөөлт итгэгч болохыг Эзэний нэрээр хүсэн ерөөе.



Сорилтоор дамжуулан дөлгөөн зүрх сэтгэлийг олсон **Моше**

Моше нь дэлхийн гадаргуу дээрх ямарч хүнээс илүү даруу хүн гэж хүлээн зөвшөөрөгдсөн хүн (Тооллого 12:3) ийм Мосегийн дөлгөөн байдлыг харуулах үйл явдал болсон юм.

Бурханы хуулийг авахын төлөө Моше Синай уул руу гарсаны дараахан Израйлийн ард түмэн алтан тугал бүтээн хиймэл шүтээн хийж гэм үйлдсэн юм. Эцэст нь Бурханы уур хилэн буухад Моше өөрийн амиа дэнчин тавьж зуучлан залбирал хийсэн юм.

"... Аяа энэ ард түмэн аймшигт нүгэл үйлджээ. Тэд өөрсдөдөө алтан бурхан бүтээжээ. Хэрэв Та одоо хүсвэл тэдний нүглийг уучлаач. Хэрэв үгүй бол Та Өөрийнхөө бичсэн номоос намайг арилгаач гэж гуйв" (Египетээс гарсан нь 32:31-32).

Мэдээж Моше нь анхнаасаа дөлгөөн сэтгэлтэй хүн биш байлаа. Тэрээр еврей хүн байсан ч Египетийн гүнжийн хүү болон огтхон ч дутагдах зүйлгүй өсөж бойжсон ч өөрийн үзэл бодлоор еврей хүний зовоож байсан египет хүнийг цохиж алсан юм. Энэ явдлаас болж Моше нэг өдрийн дотор бүх зүйлээ алдаж, зугтаж амьдардаг болсон юм. Тэгээд 40 жилийн турш өөрийн хамгийн дорд үздэг ажлыг хийж Бурханы хайрын тухай амьдралын тухай олон зүйлсийг мэдэрч чин сэтгэлээсээ өөрийгөө даруу болгосон юм.

Египетээс чөлөөлөх удирдагч Моше шиг дөлгөөн сэтгэлийг бий болгоход хамгийн чухал нь хүн тус бүрт өгөгдөх сорилтоор дамжуулан Бурханы өмнө өөрийгөө даруу болгон сайн болон хайраар өөрийгөө хөгжүүлэх явдал юм.



“Итгэлээр сайныг үйлдэхэд Бурханы ерөөлөөр бялхаж байна!”

Со Мин сог сүмд үйлчлэгч (47нас, 3-р их бүлэг 23-р хэсэг)

Би итгэгч гэр бүлд төрж өссөн ч Сөүлд ирээд ажил хийгээд Эзэнээс холдсон юм. Нэг л мэдэхэд сэтгэл хоосон мэдрэгдэж манай эгч (Со Хи жа туслагч)-нхээ удирдамжаар 1996онд Манмин Төв цуглаанд ирдэг болсон юм. Бамбай булчирхай үйл ажиллагаа ихсэлт өвчнөөсөө И Жей руг тэргүүн пасторын залбирлаар цэвэрхэн эдгэрсэн эгч маань Ариун Сүнсээр бялхам байлаа.

Дараа жилийнх нь зуны цуглаанд оролцож гайхамшигт тэмдгийг үзэж мэдрэн Бурханы амьд оршин буйг баттай мэдсэн юм. Энэ удаагийн боломжоор өнгөрсөн удаагийн гэм буруугаа ухаарч, архи болон тоглоомоо шууд орхиж аз жаргалтай итгэлийн амьдралаар амьдарч байв.

2000онд хурим хийж, Эрэгтэйчүүдийн багийн эсийн багийн удирдагчаас авахуулан хэсгийн, багийн удирдагчаар сонгогдон ажиллаж сүм болон итгэгч наргаа хүч болохыг хүсэн тэмүүлэн залбирдаг байлаа.

2009оны 12-р сард ихэнх нь итгэгчдээр бүрдсэн Лайн санхүүгийн байгууллагт орж ажиллах болсон юм. Залбирлаар Бурхандаа бүхнээ даатгаж, итгэмжтэйгээр үүргээ гүйцэтгэх тусам орлого ашиг нэмэгдээд ирэв.

Тэгж байгаад 2018оны 2-р хагасаас өөрийн эрх ашгаас болж Эзэний ивээлийг орхисон хүмүүсийг хараад би сэтгэлийнг шарх авч залбирал таслах болсон. Ариун Сүнсний бялхал ч унаж ажлын амжилт ч буурсаар гэр бүлд ч санхүүгийн бэрхшээлтэй тулгарч эхлэв.

Тэр үед манай компаниас ‘2018-2019 Шинэ оноо утгах мөргөл’-д индэрийн цэцгийг өргөн Эзэний ивээлийг хүсэн тэмүүлэн сургаал сонсож байсан миний дотор Ариун Сүнсний хүч нөлөө бий болсон юм. ‘Сүнслэг дайчин’ гэсэн сургаалийг сонсч байхад сэтгэл хөдлөж, ‘Би ч гэсэн ерөөл аваад Бурханы хаанчлалд хүч больё’ гэсэн хүсэлтэй болсон юм.

Үүний дараа залбирал тасралтгүй хийе гэж шийдээд орон нутаг руу томилолтоор явсан ч салбар цуглаанд очин Даниел залбиралд оролцох юм уу гар утсаараа GCN телевизээр дамжуулан байрандаа залбирал хийж байлаа. Багийнхаа нарийн бичиг хэсгийн ахлагчийн

хувьд хичээнгүйлэн үүргээ гүйцэтгэн “Хэрэглэгч бол хаан” гэсэн сэтгэлээр чин сэтгэлээр ажил үүргээ гүйцэтгэж байлаа.

Миний ийм өчүүхэн сайн үйлсийг харсан Бурхан цайлган хэрэглэгчидтэй уулзуулж өгч, гэрээ сайн биелэгдтэл холбоотой байлаа. Амжилтаар Бурханы тусламжыг мэдэрч, 2019оны 1-р сарын 9нд дээд зэргийн амжилт үзүүлэх боломжтой болж ерөөл авсан юм. Халлелүя! Түүнээс хойш ч ерөөл үргэлжилсээр л байв.

Эхнэр Ан Өн сүг туслагч нь баруун хөхөнд нь 3.1мм ургацаг байсан бөгөөд 2-р сарын 22ны эдгэрэл ивээлийн цуглаанаар И Сү жин пасторын гар алчуур (Үйлс 19:11-12)-р залбирал авсаны төгс эдгэрсэн юм.

Том хүү (Со Да хён, Ахлах 3-р анги) бага байхын хөлийн чигчий хуруу нь идээлдэг тул сайн алхаж чадахгүй байсан бөгөөд тэргүүн пасторын залбирлаар эдгэрч, (Со Да мин, бага 6-р анги) скит боард унаж байгаад ойчиж баруун өвдгөө гэмтээж Манмин Залбирлын газрын ахлагч И Буг ним ахлагчын залбирлаар маш хурдан эдгэрсэн юм.

Энэ мэт бүх гэр бүлээрээ Эзэнийн хайрыг мэдэрч, тэнгэрийн орны тэмүүлэл дотор аз жаргалтай гэр бүл болгож ерөөж өгсөн Бурхандаа талархал алдрыг өргөө.

Эхнэр Ан Өн сүг туслагчийн рентген зураг



Залбирал авахын өмнө 3.1 мм хэмжээтэй хөхний дугуй хэлбэрийн ургацаг харагдаж байгаа нь. (2018. 8. 22.)

Залбирал авсаны дараа 3.1мм хэмжээтэй ургацаг алга болсон нь. (2019. 2. 27.)



“Эхнэрийн маань Паркинсоны эдгэрч миний нүд хараатай болсон нь”



Гэгээсүрэн сүмд үйлчлэгч (64нас, Монгол Манмин цуглаан)

Энэ оны эхээр Бурханы гайхамшигт хүчийг мэдэрсэн юм. Бие маань маш ядарч, гэдэс хэвлийгээр усжилт явагдаж, зовиуртай байсан тул эмнэлэгт очоод шинжилгээ хийлгэтэл цөсний хүүдийн үрэвсэл гэсэн юм. Би өөрийн итгэлээ эргэн харж, мөргөл болгон дээр И Жей руг тэргүүн пасторын өвчний төлөөх залбирлыг итгэлээрээ авч, тэргүүн пасторын залбирч өгсөн гар алчуур (Үйлс 19:11-12)-г хүргэж тавин залбирч байтал хөндүүр зовиур бага багаар арилж байгааг мэдэрч 1-р сарын дундуур эмнэлэгт дахин шинжилгээ хийлгэтэл хэвийн болсон гэсэн хариу авсан юм.

Миний эхнэр (Ундрах)-д ч гайхалтай гэрчлэл бий. Эхнэр минь 2003онд Паркинсоны өвчтэй гэсэн оноштой болж өвчнөөсөө эдгэрэх гэж бүх арга замыг хайж үзсэн ч ямар нөлөө байхгүй байсан ба улам хүндэрсээр байлаа. Эцэст нь булчин нь хүртэл саажиж, ганцаараа алхаж чадахгүй, хооллож чадахгүй, огт хөдөлж чадахгүй хүнд байдалтай болсон юм. Ингэж байгаад эхнэрээ алдах вий гэсэн санаа зовох хэмжээний байлаа.

Тэгтэл 2017онд Монгол Манмин цуглааны гар алчуурын цуглаанд залбирал авсаны дараахан гэнэт бие нь сайжирч одоо ганцаараа алхдаг болж, сайн хооллож, бүр хоол хийдэг болж өдөр тутмын амьдралд бүгдийг хийдэг болов. Эхнэр маань бүх мөргөлдөө оролцож, Бурханы ивээл дотор амьдарч байна.

Үнэндээ би 17настай байхдаа зүүн нүд минь хараагүй болж, мөн ганцаардах өвчин тусч архи, болон мөрийтэй тоглоомд автан амьдарч байсан ба 2014онд том охинтойгоо уулзахаар Солонгост очоод Манмин төв сүмд явах болсон юм.

2015онд Монголдоо ирээд Монгол манмин цуглаанд суух болсон юм. Тэр жилийнхээ 10-р сард П.Батзориг ахлагчийн гар алчуурын залбирлыг авч хагалгаанд орох байсан нурууны өвчин хөндүүрээсээ эдгэрч хараагүй нүд маань хардаг болсон Халлелүя!

Энэ мэт эрхэм нандин цуглаантай уулзаж Ариун Сүнсний хүч нөлөөг амсаж, тэнгэрийн орны хүсэл тэмүүлэл дотор амьдрах туршид нөлөөлж өгсөн Бурхан Аавдаа бүх талархал алдрыг өргөө.

УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь

| Мөргөл | Цаг |
|------------------------|---------------------|
| Хүндэтгэлийн их мөргөл | Ням гариг 10: 30 |
| Үдээс хойшхи мөргөл | Ням гариг 11: 30 |
| 3 дахь өдрийн мөргөл | Лхагва гариг 18: 00 |
| 5 дахь өдрийн мөргөл | Баасан гариг 21: 30 |
| Хүүхдийн цуглаан | Ням гариг 09: 00 |
| Сурагчдын цуглаан | Бямба гариг 15: 00 |
| Залуучуудын цуглаан | Мягмар гариг 17: 00 |

залбирал цагийн хуваарь

| Ангилал | Цаг | Удирдагч |
|-----------------------|--------------------------|----------------------------------|
| Үүрийн залбирал | 05:00-06:00 | Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч |
| Өглөөний залбирал | Даваа-Баасан 09:30-10:30 | Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч |
| Оройн Даниел залбирал | Өдөр бүр 18:00- 19:30 | Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч |

Манай хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 10-р хороо 39-р сургуулийн чанх ард талд 2-р давхар саарал байр

Чуулганы утас: 7000-3707

Чуулганы ахлагчийн утас: 8870-3712

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29тоот 152-848 Солонгос Улс

Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-818-7048

http://www.manmin.org/english

www.manminnews.com

e-mail: manmininen@manmin.kr

Нийтлүүлэгч: Жаерок Лее

Редактор: Геумсун Вин